



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2013 оны 1 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Улаанбаатар хотын байгууллага, аж ахуйн нэгж, хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хотын шинэ суурьшлын бүс, дагуул хотыг хөгжүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- |                       |  |
|-----------------------|--|
| Ахлагч                | -Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг   |
| Гишүүд:               | -Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан;<br>-Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр;<br>-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг;<br>-Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл;<br>-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулга;<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан (зөвшилцсөнөөр);<br>-Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Одхүү (зөвшилцсөнөөр);<br>-Зам, тээврийн дэд сайд Х.Ержан;<br>-Эрчим хүчний дэд сайд Д.Доржпүрэв;<br>-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ганцогт;<br>-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Золжаргал;<br>-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хүрэлшагай;<br>-Улаанбаатар хотын ерөнхий архитекторч Н.Нацагддорж. |
| Нарийн бичгийн дарга: | -Нийслэлийн Засаг даргын хөрөнгө оруулалт, хот байгуулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбат.  |

2. Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулж, шинэ суурьшлын бүс, дагуул болон хаяа хотыг хөгжүүлэх талаархи саналыг энэ оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ